

Golomt Capital®

# Хөрөнгийн зах зээлийн ТОЙМ

Голомт Капитал ҮЦК ХХК-д бэлтгэв

2022.03.14

Олон улсын  
хөрөнгийн зах зээл

## Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

Америкийн индекс	Одоогийн ханш	Долоо хоногийн өмнөх ханш	Өөрчлөлт	Сарын өмнөх ханш	Өөрчлөлт	Жилийн өмнөх ханш	Өөрчлөлт
Dow Jones	\$32,944.19	\$33,293.69	-1.05%	\$34,562.09	-4.68%	\$32,778.64	0.51%
S&P 500	\$4,204.31	\$4,295.25	-2.12%	\$4,411.18	-4.69%	\$3,943.34	6.62%
Nasdaq	\$12,843.81	\$13,253.45	-3.09%	\$13,835.35	-7.17%	\$13,319.86	-3.57%

Өнгөрсөн 7 хоногт дэлхийн томоохон индекс болох Dow Jones, S&P 500, Nasdaq бүгд унажээ. Сарын өмнөх ханштай харьцуулахад уналт үргэлжилж байгаа нь эдийн засаг хүндэрч, инфляцын түвшин нэмэгдэж байгаатай холбоотой. Харин жилийн өмнөхтэй харьцуулахад зөвхөн Nasdaq өссөн байна.

Европийн индекс	Одоогийн ханш	Долоо хоногийн өмнөх ханш	Өөрчлөлт	Сарын өмнөх ханш	Өөрчлөлт	Жилийн өмнөх ханш	Өөрчлөлт
Dax	€ 13,628.11	€ 12,590.05	8.25%	€ 14,874.29	-8.38%	€ 14,569.39	-6.46%
FTSE 100	£7,155.64	£6,877.27	4.05%	£7,491.65	-4.49%	£6,737.00	6.21%

Өнгөрсөн 7 хоногт Европын томоохон индекс болох DAX 8.25 хувиар, FTSE 100 4.05 хувиар өсжээ. Үүнийг сарын өмнөх ханштай харьцуулахад 8.38 болон 4.49 хувиар буурсан байна. Харин жилийн өмнөхтэй харьцуулахад зөвхөн FTSE 100 6.21 хувиар өсжээ.

Азийн индекс	Одоогийн ханш	Долоо хоногийн өмнөх ханш	Өөрчлөлт	Сарын өмнөх ханш	Өөрчлөлт	Жилийн өмнөх ханш	Өөрчлөлт
CSI 300	¥4,306.52	¥4,418.49	-2.53%	¥4,591.44	-6.21%	¥5,128.22	-16.02%
Hang Seng	HKD 20,553.79	HKD 21,039.54	-2.31%	HKD 24,549.53	-16.28%	HKD 29,385.61	-30.05%
Nikkei 225	JPY 25,162.78	JPY 25,406.30	-0.96%	JPY 27,025.42	-6.89%	JPY 29,211.64	-13.86%

Өнгөрсөн 7 хоногт Хятадын CSI 300 индекс, Хонг Конгийн Hang Seng индекс, мөн Японы Nikkei 225 индекс унасан байна. Мөн сар болон жилийн өмнөхтэй харьцуулсан харьцаа бүгд буурсан байна. Хамгийн их хувиар буурсан индекс нь Хонгконгийн Hang Seng индекс юм.

Онцлох	Одоогийн ханш	Долоо хоногийн өмнөх ханш	Өөрчлөлт
Газрын тос	\$109	\$121.64	-10.32%
Алт	\$1,992	\$1,995	-0.16%
Мөнгө	\$26.22	\$26.16	0.23%

Өнгөрсөн 7 хоногт газрын тос 121.64-өөс 109 болж, алт 1995-аас 1992 ам.доллар болж буурсан. Харин мөнгөний ханш 26.16-аас 26.22 болж өссөн ч энэ нь дөнгөж 0.23 хувийн өсөлт юм.

**Мэдэгдэл:** Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.

## Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

### ❖ Didi-ийн хувьцаа 44%-аар унасан нь SoftBank болон Uber-ийн өгөөжийг буурууллаа

Баасан гарагт Didi компанийн хувьцааны ханш өдрийн дотор 44%-иар уналаа. Одоогийн ханш нь анх олон нийтэд зарлагдаж гарсан ханш буюу IPO ханшаасаа 87 хувиар бага байна. Didi компанийн хоёр том хувьцаа эзэмшигч болох SoftBank болон Uber их эрсдэлтэй байдалд ороод байна.

Зураг 1. Didi хувьцааны ханшийн сүүлийн долоо хоногийн бууралт



Хятад засгийн газар болон АНУ-ын Үнэт Цаас, Биржийн Комиссоос гаргасан хууль дүрмийн зөрчлөөс болж Didi компани нь АНУ-ын бирж дээр арилжаалагдах боломжгүй болсон. Тиймээс Хонг Конгийн бирж дээр арилжаалагдах шийдвэр гаргасан. Гэвч баасан гарагт Bloomberg Didi Хонконгод хувьцаагаа худалдахад шаардлагатай мэдээллийн аюулгүй байдлыг хангаагүй гэж мэдээлэв.

Softbank нь Didi-ийн 20 орчим хувийг эзэмшдэг. Анх 14 тэрбум доллараар хөрөнгө оруулж хувьцаа авсан бол одоо тэр нь ойролцоогоор 1.8 тэрбум доллар хүрнэ. Uber ойролцоогоор 12%-ийг нь эзэмшдэг ба 6-р сард 8 тэрбум гаруй доллар байсан бол өнөөдөр 1 тэрбум гаруй доллар болж буурчээ.

Didi баасан гарагт ханш нь унасан Хятадын цорын ганц технологийн компани биш. Тухайн компанид тохиолдсон үйл явцаас болж хөрөнгө оруулагчид АНУ, Хонг Конг-д давхар бүртгэлтэй Хятадын компаниудаас хөрөнгөө татаж байна. Жишээлбэл, цахим худалдааны сайтууд болох Alibaba Group, JD.com болон цахилгаан автомашин үйлдвэрлэгч Nio компаниудын хувьцааны ханш бүгд унасан.

### ❖ Уоррен Баффет Occidental Petroleum-ийн хувьцааг худалдаж авсаар байна.

Berkshire Hathaway-ийн гүйцэтгэх захирал Уоррен Баффет өнгөрсөн долоо хоногт Occidental Petroleum-ийн 91.2 сая хувьцааг 4.5 тэрбум ам.доллараар худалдаж авсан. Тэрээр энэ долоо хоногт нэмж 27.1 сая хувьцааг 1.5 тэрбум гаруй ам.доллараар худалдан авлаа.

**Мэдэгдэл:** Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.

## Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

SEC-ийн мэдүүлгээс үзэхэд лхагва, пүрэв, баасан гарагт 51.03-аас 58.58 долларын үнээр худалдан авалт хийгдсэн ба дунджаар нэг хувьцааг 56.60 доллараар авчээ. Одоо Berkshire Hathaway тус компанийн нийт 118.3 сая ширхэг хувьцааг эзэмшиж байгаа ба энэ нь 6.9 тэрбум доллар хүрнэ.

Энэ нь Berkshire компанид Occidental-ийн нийт хувьцааны бараг 12 хувийг өгч байна. Сүүлийн 12 сарын хугацаанд нефтийн үнэ өссөнтэй холбоотойгоор Occidental-ийн хувьцааны ханш бараг 90%-иар өссөн байна.

### Зураг 2. Occidental Petroleum хувьцааны ханшийн нэг жилийн өсөлт



### ❖ ОХУ-ын Төв банк ирэх долоо хоногт хөрөнгийн биржээ нээхгүй байх шийдвэр гаргалаа

АНУ, Европын Холбоо болон барууны бусад холбоотнууд Оросын эсрэг хориг арга хэмжээ авч, Оросын рублийн ам.доллартай харьцах ханш хамгийн доод түвшиндээ хүрсэн. Тиймээс ОХУ-ын Төв банк 3-р сарын 14-ний долоо хоногт Москвагийн хөрөнгийн бирж дэх хөрөнгийн зах зээлийн арилжааг нээхгүй байхаар шийдэв. Харин 3-р сарын 21-ний долоо хоногт биржээ нээх эсэх талаар тухайн үед нь мэдэгдэнэ гэв.

Мөн цахим хуудсан дээрээ гадаад валютын зах зээл, түүхий эдийн арилжаа орон нутгийн цагаар даваа гарагийн 10.00 цагт нээгдэнэ гэж бичжээ.

**Мэдэгдэл:** Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.



## Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

## Хүснэгт 1: Өнгөрсөн долоо хоногт тайлангаа зарласан компаниуд

E EARNINGS WHISPERS		Most Anticipated Earnings Releases									
		for the week beginning									
		March 07, 2022									
Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday			
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close
http://eps.sh/cal		© 2022 Earnings Whispers									

## Хүснэгт 2: Энэ долоо хоногт тайлангаа зарлах компаниуд

E EARNINGS WHISPERS		Most Anticipated Earnings Releases for the week beginning March 14, 2022									
Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday			
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close		
<a href="http://eps.sh/cal">http://eps.sh/cal</a>		© 2022 Earnings Whispers									

**Мэдэгдэл:** Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.